



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 7/69

Өлгий

Г Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Усны тухай хуулийн 28.6 заалт, Хар нуур- Ховд голын сав газрын захиргааны даргын 2022 оны 02-р сарын 23-ны өдрийн дугаар 03 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Усны тухай хуулийн 28-ийн 6 дахь заалтыг үндэслэн "Эрчим Баян – Өлгий ХК-д Өлгий сумын иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад дулаан үйлдвэрлэх түгээх дамжуулахад шаардлагатай 16170 м³ усыг нэг жилийн хугацаагаар ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Усны тухай хуулийн 29.1, 18.1.4 дэхь заалтыг үндэслэн "Эрчим Баян – Өлгий ХК –тай ус ашиглах гэрээ байгуулж ажиллахыг БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Гүлжанд үүрэг болгосугай.

3. Усны тухай хуулийн 30 дугаар зүйл дэхь заалтуудын дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ тайланг дараа оны 1-р улиралд багтаан ирүүлэхийг "Эрчим Баян – Өлгий ХК – ны захирал /Д.Тилеуберд /-д даалгасугай

4. Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг тус газрын Өлгий сумын байгаль хамгаалагч А.Дамысбек, Х.Сулушаш нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.МАРАТ